



ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол, “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын дүрмийн 5.5.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын хэмжээнд ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдээс гаргасан гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх эрх бүхий Ёс зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ёс зүйн хорооны дарга:	Захиргааны хэлтсийн дарга
Ёс зүйн хорооны гишүүд:	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч
	Дотоод аудитор
	Хуулийн зөвлөх бөгөөд ахлах мэргэжилтэн
	Тохижилт үйлчилгээний албаны дарга
	Нярав жолооч
Нарийн бичгийн дарга:	Хүний нөөц, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн хорооны үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөж, хэрэгжүүлж ажиллахыг Ёс зүйн хорооны дарга (Захиргааны хэлтсийн дарга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б.ИЧИНХОРЛОО

142200369